



I-XI/2021

Тархаасан: 2021 оны 12 дугаар сарын 13




Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 842 (3.7%)-оор өссөн байна

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 11 сард 23348 болж, өмнөх оны мөн үеэс 842 (3.7%)-оор өсжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 721 (6.0%), залилах гэмт хэрэг 2103 (52.0%), олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 256 (91.8%)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ.

Энэ оны 11 дүгээр сард 3689 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 313 (9.3%)-аар өсөхөд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эрхийн эсрэг гэмт хэрэг 132 (17.7%)-оор, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 73 (3.1 дахин)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 75 (2.1 дахин)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 66 (90.4%)-гаар, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 6 (4.0 дахин)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1305 хэргийн 110 (8.4%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2021 оны эхний 11 сард 110 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 (10.0%)-аар өсжээ. Харин 2021 оны 11 дүгээр сард 15 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 7 (87.5%)-гоор өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2021 оны эхний 11 сард 8644 зөрчил бүртгэгдсэний 6435 (74.4%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 1142 (11.7%)-оор, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 1447 (18.4%)-гоор тус тус буурчээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 11 сард 109 болж, өмнөх оны мөн үеэс 3 (2.8%)-аар өссөн байна. Харин 2021 оны 11 дүгээр сард 17 болж, өмнөх сараас 1 (6.3%)-ээр өсжээ.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний 11 сард 1305 болж, өмнөх оны мөн үеэс 261 (25.0%)-ээр, эмэгтэй хүн оролцсон хэрэг 3214 болж, 28 (0.9%)-аар, хүүхэд оролцсон хэрэг 680 болж, 35 (5.4%)-аар нэмэгдэж, харин согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 4306 болж, 165 (3.7%)-аар, бүлэглэн үйлдсэн хэрэг 1259 болж, 127 (9.2%)-гоор, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 155 болж, 31 (16.7%)-ээр тус тус буурчээ.

ЗУРАГ 2. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2021 оны эхний 11 сард 174.1 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 81.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 79.9 (31.4%) тэрбум төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 4.4 (5.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, насны бүлгээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2021 оны эхний 11 сард 16812 болж, өмнөх оны мөн үеэс 1362 (8.8%)-оор өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 857 (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2760 (16.4%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН, ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2021 оны эхний 11 сард 22.9 мянга болж, 1223 (5.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 10395 (45.4%) нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний 11 сард 7561 хүн гэмтэж, 585 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 195 (2.5%)-аар, нас барсан хүн 60 (9.3%)-аар буурчээ.
	2020	2021	2020	2021	2020	2021	
	I-XI	I-XI	I-XI	I-XI	I-XI	I-XI	
7 хүртэлх	148	146	63	76	63	49	
8-17	965	1 077	421	418	38	26	
18-29	5 706	5 980	2 344	2 129	83	82	
30-39	7 094	7 468	2 493	2 476	130	145	
40-49	4 567	4 808	1 378	1 451	138	124	
50-59	2 652	2 404	784	720	125	108	
60-69	927	821	223	221	43	34	
70, түүнээс дээш	233	215	50	70	25	17	
Улсын дүн	22 292	22 919	7 756	7 561	645	585	
Эмэгтэй	9 099	10 395	2 978	2 795	175	157	

Улсын хэмжээнд 2021 оны эхний 11 сард 61.2 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 13.6 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 26.8 (30.5%) мянгаар, баривчлагдсан хүн 2.0 (13.1%) мянгаар буурсан байна.


Авлигатай тэмцэх газарт 2021 оны эхний 11 сард 308 авлигын хэрэг бүртгэгджээ

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2021 оны эхний 11 сард 308 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17 (5.8%)-гоор өсжээ.

Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 15 (7.3%)-аар, хахууль авах гэмт хэрэг 7 (11.7%)-гоор, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг 3 (2.0 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 308 авлигын хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 220 (64.1%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 67 (19.5%) нь хахууль авах гэмт хэрэг, 39 (11.4%) нь хахууль өгөх гэмт хэрэг, 8 (2.3%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 6 (1.8%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг, 3 (0.9%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг байна.

Зураг 4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ, хэргийн төрлөөр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Авлигын гэмт хэрэг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.



Эх үүсвэр:

Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлэл
Авлигатай тэмцэх газрын мэдээлэл

Ангилал, код:

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 01 дүгээр сарын 17

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын
статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966

